



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.2. дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийг нэгдүгээр, стратегийг 2013-2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг зохицуулах, дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д. Мөнхбат), Санхүү эдийн засгийн хэлтэс (Д. Дамдиндорж)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А. Эрдэнэтуяа)-д даалгасугай.

САЙД



Н. УДВАЛ

002191

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 сарын 08 ний өдрийн 139 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ (2013-2018 он)

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

1.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн өнөөгийн байдал

Дэлхийн ихэнх улс орнууд эрүүл мэндийн тогтолцоогоо шинэ нөхцөл байдалд нийцүүлэн, хүн амынхаа эрүүл мэндийн бодит эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр өөрчлөн шинэчлэх арга замыг эрэлхийлэн эцсийн дүнд аль ч улс оронд эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэндийн анхан шатны тусламжид суурилсан нөхцөлд тусламж үйлчилгээ нь илүү хүртээмжтэй, тэгш, шударга, чанартай, зардлын хувьд үр ашигтай, эрүүл мэндийн хувьд үр дүнтэй болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкт хамтран “Эрүүл мэндийн салбарын хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүн амд ойртуулах зорилгоор 1999 оноос эхлэн өрхийн эмнэлгийг Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд тодорхой үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд Монгол улс өрхийн эмнэлгийн тогтолцоонд бүрэн шилжсэн билээ. 2013 оны байдлаар улсын хэмжээнд 217 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагийн 128 нь Улаанбаатар хотод, 89 нь аймаг, орон нутагт байрлаж, нийт хүн амын 63 хувьд нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна.

2011 онд шинэчлэгдэн батлагдсан Эрүүл мэндийн тухай хуулиар өрхийн эмнэлэг нь хувийн хэвшлийн хэлбэрээр зохион байгуулагдаж, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх зарчим дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулах талаар хуульчилсан.

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар нийт өрхийн эрүүл мэндийн төвд 2600 гаруй эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагийн 33.4 хувийг эмч, 31.4 хувийг сувилагч нар эзэлж байна. Нийт эмч нарын 46.4 хувь нь нь 2 жилийн хугацаа бүхий дадлагажигч эмч, 42.1 хувь нь 10-аас дээш жил ажилласан дадлага, туршлага бүхий эмч нар байгаа юм. Харин нийт 834 өрхийн сувилагч ажиллаж байгаагийн 82.3 хувь нь 3-аас дээш жил ажиллаж байгаа бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмч, сувилагч нарын харьцаа 1:1.06 байна. Бусад ажилчдын хувьд нийгмийн ажилтан-177, мэдээллийн технологийн чиглэлийн ажилтан-30, жолооч, нягтлан бодогч, туслах ажилтан, үйлчлэгч нар бүгд 729 ажиллаж байна.

1999-2002 онд өрхийн эмнэлгийн нийт санхүүжилтийг нэг иргэнд тооцсон санхүүжилтээр тооцож 40 хувийг улсын төсвөөс, 60 хувийг төслөөс санхүүжүүлж байгаад 2002-2006 онд төслөөс санхүүжиж байсан 60 хувийг Иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж, 2006 оны 7 сарын 1-нээс эхлэн 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлж эхэлсэн байна. Гэвч тухайн үед өрхийн эмнэлэгт олгож байсан санхүүжилтийн хэмжээ хангалтгүй байснаас шалтгаалан цалин хангамж, тоног төхөөрөмжийн хомсдол үүссэн учраас санхүүжилтийн хэлбэрийг дахин өөрчилж, нэг иргэнээр тооцон санхүүжилтийг олгох, 2000-3000 хүн амтай өрхийн эмнэлгүүдийг аймаг, орон нутагт нэгтгэх замаар үйл ажиллагааны хүрээг өргөтгөх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж ажилласан байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн өнөөгийн санхүүжилтийг 2007 онтой харьцуулахад 6-7 дахин нэмэгдсэн хэдий ч “санхүүжилт хангалтгүй” талаар байнга гомдол гарч байгаа нь нэг талаас үнийн өсөлттэй холбоотой хэмээн үзэж болох ч нөгөө талаас байгууллагын менежментийн ур чадвартай бас холбоотой байгаа юм.

Ийнхүү өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсанаас хойших арав гаруй жилийн хугацаанд нилээдгүй арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч нэг талаас хүн амын дунд өвчилсөн хойноо эмнэлэгт ханддаг эмнэлэг-үйлчилгээнд хэт шүтсэн хандлагыг өөрчлөх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг бууруулах, иргэд өрхийн эрүүл мэндийн төвд итгэх итгэл үнэмшлийг дээшлүүлэх, нөгөө талаас өрхийн эрүүл мэндийн төвүүдийн “хаалга барих” үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын чадавхийг бэхжүүлэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, үзүүлж буй тусламж үйлчилгээний хүрээг өргөжүүлж чанаржуулах шаардлагатай байна.

Мөн байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах, эмч ажилчдын харьцаа хандлагыг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, өрхийн эрүүл мэндийн төвийн менежерүүдийн чадавхийг нэмэгдүүлэх асуудал ч ихээхэн чухлаар тавигдаж байна.

1.2. Тулгамдсан асуудал

Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар хангалтгүй

- Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багц тодорхой биш, цөөхөн төрлийн тусламж үйлчилгээг түлхүү үзүүлж байгаагаас үйлчлэх хүрээний хүн амын дийлэнхи нь шатлал алгасан үйлчлүүлдэг.
- Өрхийн нийт гишүүдийн эрүүл мэндийн байдалд цогцоор нь тавих хяналт хангалтгүй ихэвчлэн өвчний улмаас хандаж буй үйлчлүүлэгчийг үзэж “Үзлэг” давамгайлсан үйлчилгээ үзүүлдэг.
- Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа хангалтгүй, олон төрлийн нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлдэг хэдий ч түүнд зарцуулах санхүүжилт

хэт бага, үйл ажиллагааны чанар хангалтгүй, тайлагнах үйл ажиллагаанд ихэнх цагаа зарцуулдаг.

- Архаг өвчний менежмент, диспансерийн үйл ажиллагаа хангалтгүй хийгддэг.
- Нийслэл хотноо үйл ажиллагаа явуулж байгаа өрхийн эрүүл мэндийн төвийн 91 хувь нь зориулалтын байртай гэх боловч тэдний 38 хувь нь, орон нутагт 61 хувь нь стандартын шаардлага хангахгүй байна.
- Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй цагдаа, хороо, өрхийн эрүүл мэндийн төв байрлах цогцолбор барилга нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг стандартын дагуу үзүүлэхэд өрөөний тоо, хэмжээ хангалтгүй байгаагаас гадна, нэг хаалгаар иргэдэд хорооны бүх үйлчилгээг хүргэж байгаа нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дөнгөж 5% лабораторийн оношлогооны багаж хэрэгсэлтэй, 30 гаруй хувь нь зүрхний цахилгаан бичлэгийн аппараттай байгаа нь тусламж үйлчилгээний хүртээмж, чанарт нөлөөлж байна.

Хүний нөөцийн хангамж, тогтвор суурьшил, цалин, нийгмийн баталгаа хангалтгүй

- Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадвар хангалтгүй. (Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний дөнгөж тал хувь нь өрхийн эмчийн, 22 хувь нь хүүхдийн эмчийн мэргэжил эзэмшсэн байгаа төдийгүй тэдгээрийн 56 хувь нь л мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна)
- Эмч нар өрхийн эмчээр ажиллах сонирхол бага, эмч нарын тогтвор суурьшил хангалтгүй.
- Цалин урамшууллын механизм хангалтгүй. Нийт санхүүжилтийн 80 орчим хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагдаж байгаа
- Цалингийн хэмжээ өрхийн эрүүл мэндийн төвүүдэд харилцан адилгүй.
- Үйлчлэх хүрээний хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн зэргээс хамаарч өрхийн эрүүл мэндийн төвүүдийг ажлын ачаалал харилцан адилгүй.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн байгууллагын ил тод байдал, ёс зүйн төлөвшил хангалтгүй.

Санхүүжилт хангалтгүй

- 1 иргэнээр тооцсон санхүүжилтийн механизм нэвтэрч жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч хангалттай бус.
- Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллагсдын цалин бага, зарим байгууллагад цалин урамшууллын ялгаа их.
- Хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж тусламж үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлж байгаа боловч бүртгэлтгүй түр оршин суугчдын санхүүжилт олгогдохгүй байгаа.

- Өрхийн эрүүл мэндийн төвд хийснээр олгох цалингийн урамшууллын механизм үгүй.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, өрхийн эрүүл мэндийн төвийн хөгжлийн цаашдын хөгжлийн чиг хандлага

Одоогоор	Цаашид
Өрхийн эрүүл мэндийн төв, болон бусад эмнэлгүүдийн хоорондох “Эргэх холбоо” хангалтгүй – Үйлчлүүлэгч өвчилсөн үедээ зөвхөн эхний удаад хандаж байгаа (ихэнх нь дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх шилжүүлэг авах зорилготойгоор ирж үйлчлүүлж байгаа)	Тусламж үйлчилгээний залгамж холбоог сайжруулж үргэлжлэх шатны эмчилгээ болон хяналтыг өрхийн эрүүл мэндийн төвөөр хийж, архаг өвчний менежментийг тогтмолжуулах
Үйлчлүүлэгч (хувь хүн) буюу өвчтөнд чиглэсэн үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлдэг.	Өрхийн нийт гишүүдийн эрүүл мэндэд чиглэсэн үйлчилгээ, тусламж үзүүлэх (Хүн амын бүлэг бүрт тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх)
Үйл ажиллагаа нь өвчтөнг эмчилж эдгэрүүлэхэд түлхүү хийгддэг.	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг илүү чухалчлах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох (нийгмийн ажилтан мэргэшсэн байх)
Үйл ажиллагаанд тусламж үйлчилгээ үзүүлэгчид буюу эмч, сувилагч нар голлох үүрэгтэй оролцдог.	Багаар ажиллах (Асаргаа, сувилгаа болон олон нийтэд хүрч үйлчлэх үйлчилгээг өргөжүүлэн нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтнүүдийг үйл ажиллагаандаа өргөнөөр татан оролцуулах)
Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд зөвхөн холбогдох албан тушаалтан, өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч нар хяналт тавьдаг.	Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд иргэдээс хяналт тавих механизмыг бүрдүүлэх, гэрээ дүгнэх багт иргэний төлөөллийг оруулах
Ихэвчлэн үзүүлсэн тусламж үйлчилгээ, хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаагаа бүртгэх, тайлагнах, мэдээлэх хэлбэрээр зохион байгуулагдсан.	Үйл ажиллагаагаа зөвхөн дотооддоо тайлагнах бус иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцан мэдээллээ солилцох, иргэд, үйлчлэх хүрээний хүн амдаа үйл ажиллагаагаа тайлагнах
Сургалт, өөрийн туршлагад суурилсан шийдвэр гаргалт зонхилж байгаа.	Үйлчлэх хүрээний хүн амынхаа эрүүл мэндийн байдалд судалгаа, шинжилгээ хийн үнэн зөв бодит мэдээлэлд үндэслэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах чадавхитай болох, (Өөрийн үйлчлэх хүрээний хүн амын өвчлөл, нас баралтын

байдалд дүн шинжигээ хийн тусламж үйлчилгээнийхээ тэргүүлэх чиглэлийг тогтоон төлөвлөлтөө хийх)

Зорилго:

Бүх нийтэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг хүн амын өсөн нэмэгдэж байгаа эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, иргэд, үйлчлүүлэгчдийн хүсэн хүлээлтэнд нийцэхүйц чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Зорилт 1: Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэн “хаалга барих” үйл ажиллагааг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлж шинэчлэн баталж хэрэгжүүлнэ. Тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулан мөрдөнө.

Өрхийн эрүүл мэндийн төвийн оношлогооны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор түргэвчилсэн оношлуур болон оношилгооны багаж төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлнэ.

Нотолгоонд суурилсан анагаах ухааны эмнэлзүйн удирдамжийг боловсронгуй болгох, нэр төрлийг нэмэгдүүлэн шинэчилж, хэрэгжилтэнд хяналт тавина.

Архаг өвчний хяналт тухайлбал, цусны даралт ихсэх, чихрийн шижин, сүрьеэ гэх мэт өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнг сайжруулах мөн удаан хугацааны асаргаа, сувилгаа шаардлага бүхий эмгэгүүдэд хөнгөвчлөх эмчилгээг өрхийн эрүүл мэндийн төвүүдээр гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний маягаар үзүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болох нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг сайжруулж үйлчлэх хүрээний хүн амдаа эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор сайн дурын ажилтан, үе тэнгийн сургагч нарыг бэлтгэнэ. Сайн дурын ажилтан, үе тэнгийн сургагч нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулна.

Төрийн бус байгуулагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Өөрийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага хамт олонд Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулна. Боловсрогдон гарсан хөтөлбөрийн дагуу багц сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

Хүлээгдэж буй үр дүн:

- Иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
- Өвчнийг эрт илрүүлэх, оношлох чадавхи нэмэгдэж “хаалга барих” үйл ажиллагаа сайжирна.
- Хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.
- Хүн амын эрүүл мэндийн талаарх асуудалд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ

Зорилт 2: Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын менежментийг боловсрох

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Өнөөгийн байдлаар өрхийн эрүүл мэндийн төвүүд нь “Нэг цэгийн үйлчилгээ”-ний хэлбэрээр цагдаа, хороотой хамт байрлаж байгаа байдлыг эргэн хянаж эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн өрөө, тасалгаа, тоног төхөөрөмж бүхий өрхийн эрүүл мэндийн төвийг бий болгох арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж хэрэгжүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвийн, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх зорилгоор дүүргийн алслагдсан хороодод өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр байгуулах, зарим өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэгтгэн зохион байгуулна.

Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулж байгаа “Гурвалсан гэрээ”-г гүйцэтгэлийн гэрээний хэлбэрээр оролцогч талуудыг болон гэрээний агуулгыг хянаж, гэрээ байгуулагч талууд болон тэдгээрийн хүлээх үүрэг хариуцлагыг илүү боловсронгуй болгох, гэрээний шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулна.

Гэрээ дүгнэх үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөллийг оролцуулах замаар иргэний хяналтыг сайжруулна.

Мөн өрхийн эрүүл мэндийн даргын хүлээх хариуцлагын механизмыг нэмэгдүүлэх зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагчтай хийх гэрээг боловсронгуй болгоно.

Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийн тусламж үйлчилгээний залгамж холбооны тасралтгүй байдлыг хангах зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг, дүрэм журам, хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон товхимол гарын авлагыг боловсруулан түгээнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, байгууллагын хөгжлийн хангахад өрхийн эрүүл

мэндийн төвийн менежерүүдийн чадавхи ихээхэн ач холбогдолтой байх болно. Иймд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн удирдлагын менежментийн чадавхийг дээшлүүлэх тасралтгүй сургалтыг зохион байгуулна.

Гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгоно. Гэрээний үнэлгээний дүнг үндэслэн “Гүйцэтгэлд тулгуурласан урамшуулал”-ын механизмыг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн

- Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа өргөжнө.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдал сайжирна.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын хариуцлагын механизм дээшилнэ.

Зорилт 3: Өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, эмч мэргэжилтнээр тогтвортой хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 3

Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлон төлөвлөгөө боловсруулна.

Өрхийн эмч, сувилагч нарыг богино хугацааны түргэвчилсэн сургалтаар бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Мөн өрхийн эмч, сувилагч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалт, онлайн сургалт болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт эмнэлзүйн тойрон сургалтанд хамруулна.

Өрхийн эрүүл мэндийн төвд өрхийн эмч, сувилагч нарын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хөшүүргийг бий болгох зорилгоор тэдний цалин урамшууллын тогтолоог боловсронгуй болгоно.

Өрхийн эмч мэргэжилтнүүдийн чадавхийг тасралтгүй сайжруулах хүрээнд улс хувийн хэвшлийн анагаах ухааны боловсрол олгох их дээд сургуул, коллежийн сургалтын хөтөлбөр чанарт үнэлгээ хийнэ. Өрхийн анагаах ухааны төгсөлтийн дараах сургалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна.

Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулна.

Улсын болон хувийн хэвшлийн анагаах ухааны боловсрол олгох их дээд сургууль, коллежийн элсэлт болон төгсөлтийн арга хэмжээний үеэр “өрхийн эмч”, “өрхийн сувилагч” мэргэжлийг сурталчлах компанит ажлыг зохион байгуулна.

Хүрэх үр дүн

- Өрхийн эрүүл мэндийн төв нь мэргэшсэн өрхийн эмч, сувилагч нараар хангагдана.
- Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллах өрхийн эмч, сувилагч нар тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн эзлэх хувийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 4

Хүн амын тоо, иргэдийн хэрэгцээнд тулгуурласан санхүүжилтийн тогтолцоог дэмжиж бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах нөхцлийг дэмжих замаар өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр санхүүжих санхүүжилтийн хэмжээг тусламж үйлчилгээний бодит зардал, үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ. Үүний тулд өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцад орсон тусламж үйлчилгээний бодит зардлыг тооцон улмаар хүн амын нас хүйс, тусламж үйлчилгээний алслагдсан байдал зэрэгтэй уялдуулан санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөтөлбөрт суурилсан санхүүжилт бүхий нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэвтрүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвийн зарим тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх үйл ажиллагаа судлан хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн даатгалаас үзүүлэх эмийн үнийн хөнгөлөлтийн механизмыг боловсронгуй болгох замаар нэг талаас эмийн зохисгүй хэрэглээг бууруулах, нөгөө талаас иргэдийн эмэнд зарцуулж буй шууд төлбөрийн хэмжээг бууруулна.

Хүрэх үр дүн:

- Өрхийн эрүүл мэндийн төвийн 1 иргэнээр тооцсон санхүүжилт нэмэгдсэн байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй уялдсан байна.
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизм нэвтэрч эхэлсэн байна.

Зорилт 5: Өрхийн эрүүл мэндийн төвд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлж эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 5

Анхан шатны тусламж үйлчилгээний бүртгэл мэдээлэлд нэгдсэн нэг стандарт бүхий программ хангамжийг нэвтрүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвөөс дээд шатлалд илгээгдэн эмчлэгдэн гарсан үйлчлүүлэгчийн мэдээний санг солилцох журмаар өвчтөний үргэлжлэх шатны эмчилгээг өрхийн эрүүл мэндийн төвөөр хянах, үргэлжлүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг үйлчлэх хүрээний хүн амынхаа үндсэн бааз мэдээллийн чиглэлээр хорооны хүн амын мэдээний сантай уялдуулж шилжилт хөдөлгөөний бүртгэл мэдээллийг сайжруулна.

Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлж байгаа тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг бууруулах зорилгоор зарим хүлээгдэл ихтэй тусламж үйлчилгээнд “цаг” авах тогтолцоог нэвтрүүлнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвийн анхан шатны бүртгэлийн маягтуудыг боловсронгуй болгох, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дээрхи чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн

- Өрхийн эрүүл мэндийн төвийн бүртгэл мэдээллийн тогтолцоо боловсронгуй болсон байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлж байгаа тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдэл буурсан байна.

ГУРАВ. СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх стратегийг 2013-2018 онд хэрэгжүүлнэ. Стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудад эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

Стратегийн хэрэгжүүлэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын тамгын газар болон эрүүл мэндийн газар, өрхийн эмнэлгүүдийн холбоо бусад төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ХЭРЭГЦЭЭ

Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх эхний үе шатанд нийт 8860.0 гаруй сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоо гарч байна. Уг санхүүжилтийг Сангийн яам болон олон улсын зээл тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамтран шийдвэрлэх замаар уг стратегийг хэрэгжүүлнэ.

ТАВ. СТРАТЕГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Стратегийн хэрэгжилтийг жил бүр тайлагнаж, хэрэгжилтийн дунд хугацааны хяналт-шинжилгээг 2015 онд хэрэгжилтийн төгсгөлийн үнэлгээг 2018 онд тус тус хийнэ.

ЗУРГАА. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Зорилго: Бүх нийтэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг хүн амын өсөн нэмэгдэж байгаа эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, иргэд, үйлчлүүлэгчдийн хүсэн хүлээлтэнд нийцэхүйц чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг үзүүлнэ		
Ерөнхий үзүүлэлт	2012	2018
Өрхийн эрүүл мэндийн төвөөр жилд үйлчлүүлсэн нэг иргэний дундаж үзлэгийн тоо	3,4	5
Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	40,9	50
Дархлаажуулалтын хамралтын хувь	98,2	99,0
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	87,8	95,0
Гэрийн төрөлтийн эзэлх хувь	0,3	0,1
ШХБХ-ны эмчилгээ хийлгэж эдгэрсэн сүрьеэгийн шинэ тохиолдлын эзлэх хувь	82,7	90,0
Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо	25	0
Эрүүл мэндийн улсын зардалд эзлэх анхан шатны тусламж үйлчилгээний зардлын хувь	18,4 хувь	30 хувь

Зорилт 1_Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэн “хаалга барих” үйл ажиллагааг сайжруулах

Хүлээгдэж буй үр дүн	- Өвчнийг эрт илрүүлэх, оношлох чадавхи нэмэгдэж “хаалга барих” үйл ажиллагаа сайжирна. - Үйлчлэх хүрээний хүн амын тусламж үйлчилгээний хүртээмж сайжирна. - Хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшилнэ. - Хүн амын эрүүл мэндийн талаарх асуудалд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ
----------------------	--

Үзүүлэлт		2012 оны түвшин	2018 онд хүрэх түвшин
1	Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгсдээс илгээсэн хувь	Суурь үзүүлэлт	30 хувиар буурсан байна.
2	Тусламж үйлчилгээний багцад		

	заагдсан оношлогоог бүрэн хийж буй өрхийн эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	-	100 хувь
3	Өрхийн эрүүл мэндийн төвөөр бэлтгэгдэн хамтран ажиллаж буй сайн дурын ажилтны тоо	-	3500-аас дээш

Зорилт 2: Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын менежментийг боловсронгуй болгох

Хүлээгдэж буй үр дүн	- Өрхийн эрүүл мэндийн төвийн эрх зүйн орчин боловсронгуй болсон байна. - Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн өрсөлдөх боломж нээгдсэн байна. - Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж үйл ажиллагаа нь жигдэрсэн байна. - Өрхийн эрүүл мэндийн төвийн хариуцлагын механизм дээшилсэн байна. - Халдвар хамгааллын шаардлага хангасан өрхийн эрүүл мэндийн төвийн тоо нэмэгдсэн байна. - Өрхийн эрүүл мэндийн төвийн менежерүүдийн чадавхи дээшилсэн байна.
----------------------	--

Үзүүлэлт		2012 оны түвшин	2018 онд хүрэх түвшин
1	Шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	-	90 хувь
3	Менежерийн чадавхийг бэхжүүлэх сургалтанд хамрагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарын тоо	Мэдээлэл байхгүй	90 хувь

Зорилт 3. Өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, эмч мэргэжилтнээр тогтвортой хангах

Хүлээгдэж буй үр дүн	- Өрхийн эрүүл мэндийн төв нь мэргэшсэн өрхийн эмч, сувилагч нараар хангагдана. - Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллах өрхийн эмч, сувилагч нар тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ.
----------------------	--

Үзүүлэлт	2012 оны түвшин	2018 онд хүрэх
----------	-----------------	----------------

			түвшин
1	Нийт өрхийн эмч нарын дотор мэргэшсэн өрхийн эмчийн эзлэх хувь	46 хувь	80 хувь
2	Өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн сувилагч нарын хувь	27 хувь	60 хувь
3	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь	65.6* (2007)	90%

Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн эзлэх хувийг нэмэгдүүлэх

Хүлээгдэж буй үр дүн	- Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт нэмэгдэнэ - Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ - Эмч нарт хийснээр олгох цалин, урамшууллын механизм бүрдэнэ. - Өрхийн эрүүл мэндийн даатгал хэрэгжиж эхэлсэн байна.
----------------------	---

Үзүүлэлт	2012 оны түвшин	2018 онд хүрэх түвшин
1 Өрхийн эрүүл мэндийн төвд даатгалаас санхүүжүүлж байгаа тусламж үйлчилгээний төрлийн тоо	0	4
2. Өрхийн эрүүл мэндийн төвийн 1 иргэнд тооцсон санхүүжилтийн дундаж хэмжээ	12.500 төг	50.000 төг

Зорилт 5: Өрхийн эрүүл мэндийн төвд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх

Хүлээгдэж буй үр дүн	- Иргэдийн хүлээгдэл чирэгдэл буурна. - Ажлын ачаалал буурна. - Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалт сайжирна.
----------------------	---

Үзүүлэлт	2012 оны түвшин	2018 онд хүрэх түвшин
1 "Цаг" авах үйлчилгээг нэвтрүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	0	60 хувь
2 Мэдээллийн сүлжээнд холбогдсон өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	Мэдээлэл байхгүй	100 хувь

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх 2013- 2015 оны төлөвлөгөө

№	Үйл ажиллагааны хүрээ	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд	Эх сурвалж	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага	Төсөв / саяар (₮-өөр) оноор		
							2013	2014	2015
Зорилт 1. ИӨрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэн "хаалга барих" үйл ажиллагааг сайжруулах									
1.1	Түргэвчилсэн оношлуурын аргаар хийх лабораторийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Түргэвчилсэн оношлуураар хийх шинжилгээний нэр төрлийг Тусламж үйлчилгээний багцад тусгах	Тусламж үйлчилгээний багцад туссан түргэвчилсэн оношлуурын тоо	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	НЭМГ, МӨАУМХ	1.5		
		Шаардагдах түргэвчилсэн оношлуураар хангах тооцоо судалгаа хийх	Хийгдсэн судалгааны тоо	Судалгааны тайлан	ЭМХТ	НЭМГ, ДЭМН,	15.0		
		Шаардагдах санхүүжилтийн төсвийг боловсруулах	Тооцсон санхүүжилтийн төсөв	төсвийн санал	ЭМЯ,	НЭМГ	5.0	5.0	
		Эрүүл мэндийн салбарын болон өрхийн эрүүл мэндийн төвийн төсөвт тусгах	Төсөвт суусан санхүүжилт	Батлагдсан төсөв	ЭМЯ,	ӨЭМТ	2.5	2.5	
		Шаардагдах түргэвчилсэн оношлуураар хангах	Түргэвчилсэн оношлуураар хангагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	ЭМЯ, Өрхийн эрүүл мэндийн төвийн тайлан	ЭМЯ	НЭМГ, Аймгийн ЭМГ, ДЭМН,	2400.0	2400.0	
		Түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан эмч сувилагч нарын тоо	Сургалтын тайлан ӨЭМТ-ийн тайлан	ЭМХТ	НЭМГ, ДЭМН,	50.0	50.0	
		Түргэвчилсэн оношлуур ашиглах аргачлал гарын авлага боловсруулах, хэвлэх, түгээх	Боловсрогдон гарсан гарын авлагын тоо	Гарын авлага	ЭМЯ,	ЭМХТ, МӨАУМХ	32.0		

1.2	Оношлогооны нэр төрлийг нэмэгдүүлэх, нэмэгдүүлэх багц, өрхийн эрүүл мэндийн стандартад тусгах	Оношлогооны нэр төрлийг нэмэгдүүлэх жагсаалтын тусламж үйлчилгээний багц, өрхийн эрүүл мэндийн стандартад тусгах	Тусламж үйлчилгээний багц, өрхийн эрүүл мэндийн оношлогооны нэр төрлийн	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ,	НЭМГ, МӨАУМХ	5.0		
	Оношлогоонд шаардагдах багаж төхөөрөмжөөр хангах тооцоо судалгааг хийх	Оношлогоонд шаардагдах багаж төхөөрөмжөөр хангах тооцоо судалгааг хийх	Гарсан судалгааны тоо	Судалгааны тайлан	ЭМХТ	НЭМГ, ДЭМН,	5.0		
	Шаардагдах санхүүжилтийн төсвийг боловсруулах, төсөвт суулгах	Шаардагдах санхүүжилтийн төсвийг боловсруулах, төсөвт суулгах	Тооцсон төсөв	Төсвийн санал	ЭМЯ,	НЭМГ	5.0	5.0	5.0
	Оношлогооны аргад эмч, сувилагч нарыг сургах сургалтыг зохион байгуулах	Оношлогооны аргад эмч, сувилагч нарыг сургах сургалтыг зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан эмч сувилагч нарын тоо	Сургалтын тайлан	ЭМХТ	НЭМГ, ДЭМН,		75.0	50.0
1.3.	Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцад өдрийн эмчилгээ, нөхөн сэргээх, эмчилгээний төрлийг оруулах	Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцад өдрийн эмчилгээ, нөхөн сэргээх, эмчилгээний төрлийг оруулах	Батлагдан гарсан өдрийн болон нөхөн сэргээх эмчилгээний төрөл, жагсаалт	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ, ХАХНХЯ	НЭМГ, МӨАУМХ	5.0	5.0	
	Өдрийн эмчилгээ, нөхөн сэргээх эмчилгээнд шаардагдах багаж тоног, төхөөрөмжийн судалгааг гаргах хэрэгцээг тооцох	Өдрийн эмчилгээ, нөхөн сэргээх эмчилгээнд шаардагдах багаж тоног, төхөөрөмжийн судалгааг гаргах хэрэгцээг тооцох	Хэрэгцээ тооцсон судалгааны тоо	Судалгааны тайлан	ЭМХТ	НЭМГ, МӨАУМХ		15.0	
	Шаардагдах санхүүжилтийн тооцоог гаргаж төсөвт суулгах	Шаардагдах санхүүжилтийн тооцоог гаргаж төсөвт суулгах	Төсөвт суусан санхүүжилт / хувиар/	Батлагдсан төсөв	ЭМЯ,	ӨЭМТ		5.0	5.0
1.4	Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сайн дурын ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах	Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сайн дурын ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах	Бэлтгэсэн сайн дурын ажилтны тоо	ДЭМН-ын тайлан	НЭМГ	МӨАУМХ	25.0	25.0	25.0
	Сайн дурын ажилтануудад зориулсан сургалтын цогц гарын авлага боловсруулах	Сайн дурын ажилтануудад зориулсан сургалтын цогц гарын авлага боловсруулах	Боловсруулан гаргасан гарын авлагын тоо	ЭМЯ, Ажлын хэсэг	ЭМЯ	Ажлын хэсэг		12.0	12.0
	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, дээшлүүлэх чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран сургалт сурталчилгаа зохион байгуулах	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, дээшлүүлэх чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран сургалт сурталчилгаа зохион байгуулах	Сургалт сурталчилгаа хамтран зохион байгуулсан байгууллагын тоо	ЭМЯ, бусад холбогдох байгууллагын тайлан	ЭМЯ	НЭМГ, ДЭМН, МӨАУМХ	10.0	50.0	50.0
	Байгууллага, хамт олонд суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өрнүүлэх эрх зүйн орчинг бий болгох	Байгууллага, хамт олонд суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өрнүүлэх эрх зүйн орчинг бий болгох	Батлагдан гарсан дүрэм, тушаал зааврын тоо	Гарсан дүрэм заавар, тушаал	ЭМЯ	НЭМГ		15.0	

Зорилт 2. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын менежментийг боловсронгуй болгох							46.3	115.8	86.8
2.1	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний өвчтөний аюулгүй байдал, тав тух, халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор "Нэг цэгийн үйлчилгээ" (хороо, эмнэлэг, цагдаа нэг дор байрлаж байгаа) –нд үнэлгээ хийж, өөрчлөн сайжруулах санал боловсруулах	Хийгдсэн үнэлгээний тоо Боловсрогдон гарсан саналын тоо Санал хэлэлцүүлсэн уулзалтын тоо	Үнэлгээний тайлан	ЭМХТ	НЭМГ, ДЭМН, МӨАУМХ			
		Үнэлгээнээс гарсан зөвлөмж, бодлогын саналд үндэслэн өрхийн эрүүл мэндийн төвийн байрлал, зохион байгуулалтыг өөрчлөх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран шат дараатайгаар хэрэгжүүлэх	Хамтран ажилласан байгууллагын тоо Шийдвэрлэсэн асуудлын тоо, төрөл	Үйл ажиллагааны тайлан	ЭМЯ	НЭМГ, Аймгийн ЭМГ, ДЭМН, МӨАУМХ	5.0	50.0	50.0
		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, оношлох, эмчлэх, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр зохион байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх	Гарсан тушаал шийдвэрийн тоо	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	НЭМГ, Аймгийн ЭМГ, ДЭМН, МӨАУМХ	5.0	15.0	
		Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчилсан компани ажлыг зохион байгуулах	Зохион байгуулагдсан үйл ажиллагааны төрөл, зохион байгуулсан арга хэмжээний тоо	Үйл ажиллагааны тайлан	НЭМГ, Аймгийн ЭМГ, ДЭМН, МӨАУМХ	ДЭМН, МӨАУМХ	15.0	30.0	30.0
		Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм, стандартыг шинэчлэн боловсруулах	Боловсрогдон гарсан стандарт дүрмийн тоо, төрөл	Холбогдох тушаал шийдвэр	ЭМЯ	Ажлын хэсэг	5.0		
		Өрхийн эрүүл мэндийн төвийн менежерийн чадавхийг бэхжүүлэх	Сургалтанд хамрагдсан менежерүүдийн тоо Зохион байгуулсан	Сургалтын тайлан ӨЗМТ-ийн тайлан	Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМН, МӨАУМХ	5.0	5.0	5.0

Мэргэшсэн өрхийн эмч, сувилагч нарыг бэлтгэх	Өрхийн эрүүл мэндийн төвийн хариуцлагын механизмыг дээшлүүлэх зорилгоор гурвалсан гэрээ, өрхийн ахлагчтай хийх үр дүнгийн гэрээг боловсронгуй болгох	Өөрчлөлт оруулж боловсронгуй болгох зорилгоор зохион байгуулсан санал асуулга, хэлэлцүүлэг, уулзалтын тоо	Гурвалсан гэрээ, өрхийн менежертэй хийх гэрээний загвар баталсан тушаал шийдвэр	ЭМЯ	ДЭМН, МӨАУМХ	1.5		
	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах	Шинэчлэн боловсруулагдаж батлагдсан шалгуур үзүүлэлтийн тоо	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	Аймаг нийслэлийн ЭМГ	7.5		
	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах гарийн авалгаар хангах	Магадлан итгэмжлэлд хамрагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	Магадлан итгэмжлэлийн жилийн эцсийн тайлан	Аймгийн ЭМГ, ДЭМН	ӨЭМТ, МӨАУМХ	2.3	14.0	
Зорилт 3. Өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадаахыг бэхжүүлж, эмч мэргэжилтнээр тогтвортой хангах								
Мэргэшсэн өрхийн эмч, сувилагч нарыг бэлтгэх	Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллах эмч нарыг өрхийн эмчийн сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан өрх сумын эмч нарын тоо Зохион байгуулсан нийт сургалтын тоо	Сургалтын тайлан ӨЭМТ-ийн тайлан	ЭМХТ	ЭМЯ, Аймаг нийслэлийн ЭМГ	25.0	25.0	25.0
	Сувилагч нарыг өрхийн сувилахуй судлалын чиглэлээр мэргэжжүүлэх сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан өрхийн сувилагч нарын тоо Зохион байгуулагдсан сургалтын тоо	Сургалтын тайлан ӨЭМТ-ийн тайлан	ЭМХТ	Аймаг нийслэлийн ЭМГ, ДЭМН, Дүүргийн засаг даргын тамгын газар, ӨЭМТ	12.0	12.0	12.0
	Мэргэшсэн өрхийн эмч, сувилагч нарыг өрхийн эрүүл мэндийн төвд ажиллуулах нөхцлийг цалин, урамшуулалтай асуудлыг холбогдох дүрэм, журамд тусган эрх зүйн орчинг бүрдүүлэх	Асуудлыг тусган батлагдсан дүрэм журмын тоо	Эрүүл мэндийн сайдын тушаал бусад эрх зүйн актууд	ЭМЯ	Аймаг нийслэлийн ЭМГ, ДЭМН, Дүүргийн засаг даргын тамгын газар, ӨЭМТ		15.0	
	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зураглал, ажлын ачааллыг тооцсон цалингийн урамшууллын механизмыг нэвтрүүлэх	Урамшууллын механизмыг нэвтрүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвийн тоо / хувь/	НЭМГ-ын тайлан, ӨЭМТ-ийн тайлан	Аймаг, нийслэлийн ЭМГ	ӨЭМТ		5.0	5.0

	Өрхийн эмчийн мэргэжлийг сурталчлах компанид ажлыг анагаахын сургуульд элсэгчид болон төгсөгчдийн дунд зохион байгуулж хэвших	Зохион байгуулагдсан компанид ажлын тоо	Сурталчилгааны тоо	Оролцсон өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	Үйл ажиллагааны тайлан	Аймаг, нийслэлийн ЭМГ	МӨАУМХ, Дүүргийн ЭМН	25.0	25.0
	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага боловсруулах, түгээх							12.0	
	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн харьцаа хандлага зөвлөгөө өгөх үр чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	Хамрагдсан эмч, сувилагч нарын тоо	Сургалтын тайлан	Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМЯ, ЭМХТ, МӨАУМХ, Дүүргийн ЭМН		5.0	5.0
Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн эзлэх хувийг нэмэгдүүлэх									
4.1	Өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх	Зарим тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалд хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх	Эрүүл мэндийн даатгалд хамруулах тусламж үйлчилгээг баталгаажуулсан журмын тоо	Холбогдох яамдын хамтарсан тушаал	ЭМЯ	ХАХНХЯ,		5.0	11.5
	Тусламж үйлчилгээний хэрэгцээ, түүнийг үзүүлэх төвийн чадавхи, тусламж үйлчилгээний бодит өртөг тулгуурлан 1 иргэнээр тооцох санхүүжилтийг шинэчлэх	1 иргэнээр тооцсон санхүүжилтийг нэмэгдүүлсэн хувь	Засгийн газрын тогтоол	ЭМЯ	ХАХНХЯ, СЯ			10.0	10.0
	Гүйцэтгэлийн үр дүнд тулгуурлаж санхүүжилтийг өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн үр дүнтэй уялдуулан боловсронгуй болгох журам боловсруулан	Журмын тоо	Журмыг мөрдөж хэвшсэн өрхийн эрүүл мэндийн төвийн тоо /хувь/	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	СЯ		1.5	1.5
Зорилт 5: Өрхийн эрүүл мэндийн төвд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх									
								15.0	65.0
									465.0

5.1	Өрхийн эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа анхан шатны бүртгэлийн маягтуудыг боловсронгуй болгох чиглээлр үнэлгээ хийх	Хийгдсэн үнэлгээний тоо	Үнэлгээний тайлан	ЭМЯ	ЭМХТ	5.0	
	Судалгааны дүнд үндэслэн анхан шатны маягтуудыг шинэчлэх боловсруулах	Өөрчлөлт оруулж боловсронгуй болгосон анхан шатны бүртгэлийн маягтын тоо, төрөл	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	ЭМХТ	10.0	
5.2	Өрхийн эрүүл мэндийн төвд анхан шатны бүртгэл хийх, мэдээг цуглуулах, дамжуулах, боловсруулах, тайлагнах үйл явцыг бүрэн автоматжуулах	Цаг авах тогтолцоог нэвтрүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	Үйл ажиллагааны тайлан	ЭМЯ	Аймгийн ЭМГ, ДЭМН, НЭМГ, ӨЭМТ	15.0	15.0
	Өрхийн эрүүл мэндийн төвд хэрэглэгдэх нэгдсэн программ хангамжийг боловсруулах	Боловсруулагдсан программ хангамжийн тоо	Үйл ажиллагааны тайлан	ЭМЯ	ЭМХТ, Ажлын хэсэг	50.0	50.0
	Мэдээллийн технологийн техник тоног төхөөрөмжөөр хангах	РС, хэвлэх төхөөрөмж гэх мэт тоног төхөөрөмжөөр хангагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	Үйл ажиллагааны тайлан	ЭМЯ, Аймаг дүүргийн засаг даргын тамгын газар	Аймаг нийслэлийн ЭМГ, ӨЭМТ, Дүүргийн ЭМН		300.0
	Программ хангамжийг ашиглах сургалт зохион байгуулах	Зохион байгуулагдсан сургалтын тоо Хамрагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн тоо Хамрагдсан эмч ажилтнуудын тоо	Сургалтын тайлан	ЭМЯ ЭМХТ	Аймаг нийслэлийн ЭМГ, Дүүргийн ЭМН		100.0
Бүгд						2641.8	2980.8
							3238.3